

БҮЛЭГ 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1.ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.1 Төслийн нэр

“ҮҮДИЙН” ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРД

1.1.2 Төслийн зорилго

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар төсөл хэрэгжүүлэх хугацаанд 396,452 мян.тонн хүдэр олборлон экспортолж, тодорхой тооны хүмүүсийг ажлын байраар ханган, өөрийн компанийн болон улс, орон нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.


1.1.3 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Дорнын хүдэр” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: **9011126115**
- Регистрийн дугаар: **5197201**
Хаяг: Дорнод аймаг Булган сум Баянуул Үүдийн ам
- 1-1 тоот
- Утас: 99892853, 98118928

1.1.4 Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Үүдийн төмрийн хүдрийн орд нь Дорнод аймгийн Матад, Булган сумдын заагт орших Үүд нэртэй газарт, ашигт малтмал ашиглалтын MV-016962 тоот тусгай зөвшөөрөл бүхий 544.54 га талбайг эзлэн оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 705 км, Дорнод аймгаас баруун урагш 90км Дорнод аймаг, Матад сумыг холбосон төв замаас баруун тийш 9 км зайд байрлана.



Зураг-№1. Үүд төмрийн хүдрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай

1.2.ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТЕХНИК ТЕХНОЛОГИ

1.2.1 . Ордын нөөц, техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Уурхай нь 2025 онд жилийн 40.20 %-ийн дундаж агуулгатай 203.82 мян.тн хүдэр олборлон 89.82 мян.тн баяжмал баяжуулна. Төслийн хугацаанд 1 ил уурхай үүснэ. Ашиглалтын жилүүдээс гадна уурхайн хаалт болон нөхөн сэргээлт, нөхөн сэргээсэн талбайг хадгалж хамгаалах 1 жилийн хугацааг оруулбал уурхай нь 9 жил ажиллах юм.

1.2.2. Ил уурхайн төлөвлөлт

2025 онд үйлдвэрлэлийн нөөцөөр ашиглалтын хаягдлын 3.74%, бохирдлыг 5.61%-иар тооцож нийт 568.4 мян.тн хөрс хуулж, 203.82 мян.тн хүдэр олборлоно. Ил уурхайн сар бүрийн календарь төлөвлөгөөг хийхдээ ил уурхайн үе шатуудыг хөрс хуулалтыг жигд байлгах зорилго болгон ажилласан. Ил уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт-№1. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

2025 он														
Төрөл	Хэмжих нэгж	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
Хөрс хуулалт	Мян.тн			57.2	56.83	56.83	56.83	56.83	56.83	56.83	56.83	56.83	56.83	568.40
Хүдэр олборлолт /үйлдвэрлэлийн нөөц/	Мян.тн			20.4	20.4	20.4	20.4	20.4	20.4	20.4	20.4	20.4	20.4	203.82

1.2.3. Ашиглалтын технологи

Ордын хэмжээнд бодитой болон боломжтой (В+С) нөөцийн зэрэглэлээр 37.3-50.01% төмрийн, 0.08-0.1% хүхрийн, 0.08-0.1% фосфорын агуулгатай нийт геологийн нөөц 4296.13 мян.тн хүдрийг 36.61%-ийн дундаж агуулгатай, төмрийн нөөцийг 1572.77 мян.тн-оор, үүнээс бодитой В зэргийн нөөцийг 2193.15 мян.тн хүдрийг 38.75%-ийн дундаж агуулгатай, төмрийн нөөцийг 850.9 мян.тн, боломжтой С зэргийн нөөцийг 2099.97 мян.тн хүдрийг 34.37%-ийн дундаж агуулгатай, төмрийн нөөцийг 721.8 мян.тн, төмрийн нөөцийг тооцсон байна.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр нийт 100 орчим хүний ажлын байр шинээр бий болох ба орон нутгаас нийт ажилчдын 30 гаруй хувийг ажлын байраар хангаж ажиллах боломжтой байна. Нэг

ажилчны сарын дундаж цалингийн хэмжээ 1.5 сая.төг байхаар тооцов. Улс орон нутгийн төсөвт 39.7 тэрбум төгрөг төлхөөр байна. Нийт борлуулалтын орлогын 17.6%-ийг эзлэж байна.

Ордыг нээх. Үүдийн төмрийн хүдрийн ил уурхайн нээлтийг 2019 оны 11 сарын 20 нд нээсэн. Хөрс тээвэрлэлт болон хүдэр тээвэрлэлтийн дотоод капитал траншейн 1 байхаар төлөвлөж нээсэн. Тус траншейнуудаас хөрс хуулалтын ажил явагдаж байгаа ба уурхайн эцсийн хүрээ хязгаарт байрлана.

Хөрс, хүдэр тээвэрлэх зориулалт бүхий траншейн-№1 амсарын цэг (X= 588685.1941, Y= 5398332.5256 Z=1101.0)-аас уулын ажлыг эхэлнэ.

2025 онд календарьчилсан төлөвлөгөөний дагуу 1-р ил уурхайг үргэлжлүүлэн олборлолтын ажлыг явуулан хүдрийг олборлон дуусгана. Олборлосон хүдрээ баяжуулах үйлдвэрийг ашиглалтад ортол түр овоолго болгон асгаж хураана.

Ордыг ашиглах. Хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажил эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу гадаргаас ойролцоогоор 0.5 м орчим зузаантай хэсгийг бульдозероор хуулж экскаватороор автосамосвалын хослолоор тээвэрлэн ашиглалтын талбайд саад болохооргүй зайнд түрж овоолго үүсгэнэ.

Хүснэгт-№1-2. Ашиглалтын технологи

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Өрөмдлөг тэсэлгээ 1.2. Ухаж ачих 1.3. Тээвэрлэх 1.4. Овоолох
	2. Хүдэр олборлолт	2.1. Өрөмдлөг тэсэлгэ 2.2. Ухаж ачих 2.3. Тээвэрлэх 2.4. Овоолох

1.2.4 Үүдийн төмрийн ордын хүдэр баяжуулах технологи

Үүдийн уурхайн баяжуулах үйлдвэр нь

Бункейр → Конейвер → Бутлуур → Конейвер → Шигшүүр →

Конейвер → Бутлуур → Конейвер → Соронзон сеператор →

Конейверууд гэсэн дараалалтай явагддаг.

1.2.5 Уурхайн тээвэр

Уурхайн автозамыг байгуулахдаа хүдэр олборлолтын ажлын талбайгаас хүдэр хадгалах агуулах хүртэлх, хөрсний чулуулгийг гадаад овоолго хүртэл тээвэрлэх зай нь хамгийн бага байхаар тооцож байгуулна. Үүдийн төмрийн хүдрийн ордын хүдрийг нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд тодорхойлсон, тодорхой гүн хүртэл ил уурхайгаар дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, зүүнээс баруун тийш уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийсний дараа экскаватороор хутган автосамосвалд ачиж, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг хүдрийн агуулах хүртэл тээвэрлэн байршуулна.

Гадаад тээвэр

Баяжуулах үйлдвэрээс гарсан төмрийн хүдрийн баяжмалыг Матад БЭШН ХХК-ны 50-70 тонны даацтай автамашинаар 230км сайжруулсан шороон замаар Бичигтын боомт хүртэл тээвэрлэнэ. Манай компани нь 45км сайжруулсан шороон замыг 2025 онд багтаан дуусгах стандартын шаардлага хангасан тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

2.1.ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс ил уурхайн аргаар төмрийн хүдэр олборлох үед геологийн тогтоц, хөрс, агаар, бэлчээр, ургамал зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд голлох нөлөөллийн үнэлгээнд дээрх асуудлуудыг авч үзэх болно. Голлох нөлөөллийг тодруулахад доорх 3 зүйлийг анхаарах шаардлагатай болдог (Environmental Resource Guide, 1993, USE). Үүнд:

- Үйл ажиллагааны бохирдлын түвшинг тодорхойлж, харгалзан үзэх
- Нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг тодорхойлох
- Төслийн алтернатив хувилбаруудыг зааж өгөх явдал юм.

Үүдийн төмрийн хүдрийн ил уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн ба тархалтын хэмжээ болон үр дагавар нь харилцан адилгүй юм.

2.2.1 Геологийн тогтоц, хөрс

Орчны үржил шимт хөрс болон малын бэлчээр бүхий талбай уурхайн малталтад орж, гадаад овоолгуудад дарагдахаас гадна хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөх юм. “Дорнын хүдэр” ХХК-ий Үүдийн төмрийн уурхайн эдэлбэрт 0,9 га талбай, хөрсний овоолгод нийт 568,40мян.м³ хөрс хөрсний овоолго дээр бууна. Уурхайгаас ухаж гаргасан уулын цул болон олборлосон ашигт малтмалын хэмжээ нь нөлөөлөлд өртсөн газрын хэмжээтэй нягт уялдсан байдаг. Иймд газар ашиглалтын байдалд үнэлгээ дүгнэлт өгөхийн тулд нөлөөлөлд өртөх газрын итгэлцүүрийг дараах томъёогоор тодорхойлно.

Төсөл хэрэгжих хугацаанд

$$k = S_{m0} + S_{g0}/Q = 16.94 + 13.54/541202.8 = 0.563 \text{ м}^2/\text{тн}$$

Sum - Уулын малталтанд өртөх талбай, га

Sgo – Гадаад овоолгын эзлэх талбай, га

Q – Олборлох төмрийн баяжмалын хэмжээ

Үүнээс үзэхэд уурхайн ашиглалтын нийт хугацаанд тус уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр 1 тонн төмрийн хүдэр олборлоход 0.56 м²/тн талбай өртөж байгаа нь газар ашиглалтад сөрөг нөлөөлөхөөр байна. Өөрөөр хэлбэл хэдийгээр ашигт малтмал ашиглах лицензээр олгогдсон талбайн хэмжээ нь их боловч уул уурхайн малталтаас нөлөөлөлд

өртөх талбайн хэмжээ харьцангуй бага байна. Иймд хүдэр олборлохдоо аль болох дотоод овоолгод хийсэн тохиолдолд газар ашиглалтыг сайжруулах боломжтой болох юм.

Агаар орчин:

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулж байна. Үүнд:

- ✓ Өрөмдлөг тэсэлгээний ажлын үед үүсэх тоос, хорт хий
- ✓ Хөрс хуулах, төмрийн хүдэр олборлох үед үүсэх тоос
- ✓ Хүдэр баяжуулах, боловсруулах үед үүсэх тоос
- ✓ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий
- ✓ Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос
- ✓ Хөрс болон чулуу, хүдрийг тээвэрлэх үед хийсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.

Үүнээс үзэхэд малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшилт зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд харилцан адилгүй байдаг.

Агаар орчны тоосжилтыг багасгах нэг арга бол уурхайн орчны эвдрэлд орсон газрыг услаж чийглэж байхаас гадна аль болох богино хугацаанд нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байх, гадаад тээврийн замыг сайжруулсан шороон зам болгох, дотоод тээврийн замыг нэмж засч сайжруулах олон салаа зам гаргахгүй явдал юм.

Хөрс, ургамал:

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөнд шүлтлэг металлын агууламж нэмэгдэж, хөрсний кали, фосфорын элементүүд багасаж улмаар бүрхүүлд нөлөөлж ургамал эрт хагдрах, хөрс элэгдэх үндсэн шалтгаан болдог. Судалгаанаас үзвэл газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч шилмүүсэнд нь түлэгдэлт үүсэх, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна. Ургамлын бүрхүүлийн энэхүү өөрчлөлт нь хүний нүдэнд ил харагдаж байдаг бол үүний цаана нүдэнд харагдахгүй ихээхэн өөрчлөлт орох, фотосинтезийн идэвх буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог байна.

Дээр дурдсанаас үзвэл төмрийн хүдрийн уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр байгаль орчинд үзүүлэх экологийн гол сөрөг үр дагавар нь газрын хурдсыг эвдэх, нүх, карьер, овоолго үүсгэх улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархаж байна. Иймд байгаль хамгаалах арга хэмжээнүүдийг авч сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагатай ба уурхайн нөлөөлөлд өртөж буй газруудын ургамал хөрсний судалгаа хийн тэдгээр ургамалуудыг нэг бүрчлэн ангилан тарь ургуулах, нутагшуулах.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй тэсрэх бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтад байнгын хяналт тавьж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

БҮЛЭГ 3.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

“Дорнын хүдэр” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Дорнын хүдэр ХХК-ийн Үүдийн төмрийн хүдрийн ордын олборлолтын ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө батлагдсаны дараа БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардалд 2025 онд 12.4 сая.төг оруулж өгсөн болно.

3.2.ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ГОЛ ШААРДЛАГА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ, ОХШХ-ийг боловсруулав.

Нөгөө талаас төслийг хэрэгжүүлэгч “Дорнын хүдэр” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлсэн байгаа.

БОМТ-г боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг удирдлага болголоо.

3.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

“Үүд”-ийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн БОМТ-г Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба БОМТ-ний хүрээнд авч хэрэгжүүлэхэд **12.400.000 сая.төгрөг** зарцуулахаар байна.

Хүснэгт-№3.1. БОМТ-ний зардын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (сая.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	2400.0
1.1		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
1.2		Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	2000.0
1.3		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1300.0
1.4		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2000.0
1.5		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1500.0
		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгах ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1000.0
		Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1200.0
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1000.0
Нийт зардал			12400.0

Мөн Монгол улсын ерөнхийлөгч Хүрэлсүхийн санаачилсан тэрбум мод төслийг дэмжиж Матад суманд 100ш , Булган суманд 100ш мод тарьж ургуулна.

3.4.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу Үүдийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

БОМТ-ний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

3.4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Үүдийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх агаарын чанар, газрын гадарга болон хэвлий, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулав.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг 1 жилээр боловсруулсан бөгөөд нийт 2400,0 сая төгрөг зарцуулах тооцоолол гарсан.

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Хүснэгт-№3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, буруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа		Баримтоах стандарт, аргачлал
			2025 он	Давтамж	
АГААРЫН ЧАНАР					
Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тррсжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	-	-	Салхины хүч ихээр нэмэгддэг үеүдэд	MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэл хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4900-2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
	Уурхайн тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	0.3	0.3	Хуурайшилтг ай үеүдэд 3 хоногт 1 удаа	
Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	0.2	0.2	Үйл ажиллагааны туршид	
Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсч, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн замд хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засч сайшруулах	0.1	0.1	Үйл ажиллагааны туршид	
	Тээврийн хэрэгслийн машинд GPS суурилуулан төлөвлөсөн иаршрутаар явж байгаад хяналт тавих	0.1	0.1	Үйл ажиллагааны туршид	

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд Монгол улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх. Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Үйл ажиллагааны зардалд тусгах	-	Үйл ажиллагааны туршид	
ГАЗРЫН ГАДАРГА ХӨРСӨН БҮРХЭВЧ					
Олборлолтын хэмжээ нэмэгдсэн үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайн хөрсөн бүрхэвч гадарга зайлуулагдах	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	0.1	0.1	Үйл ажиллагааны туршид	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс, хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм” MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”, MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага”, MNS5850-2008 “Хөрсний чанар,
Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	-	-	Үйл ажиллагааны туршид	
Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг 2025 онд цементлэх, цаашид засч сайжруулж ажиллана.	0.2	0.2	Үйл ажиллагааны туршид	
Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар тээвэрлэх ба хүнд даацын	Уурхайн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, цаашид арчилж тордох	Агаарын чанарын хэсэгт	-	2025 онд	

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

машин механизмын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэлд орох, сул шороо ихээр үүсэх		тусгагдсан			хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, MNS5914-2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт”, MNS5915-2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”, MNS5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS5918-2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
	Замын усалгааг тоосжилт ихтэй үеүдэд хийж байх	0.2	0.2	Үйл ажиллагааны туршид	
Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан	-	Үйл ажиллагааны туршид	
УСАН ОРЧИН					
Ил уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэж газрын доорх ус хомсдох	Усны эх үүсвэрийг тодорхойлох, ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	0.3	Үйл ажиллагааны туршид	
	Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах (ус шавхах насос, худаг г.м)				
Уурхайн ухаш үүсэх, далан байгуулах, суваг шуудуу хатах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсцын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх	Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр, төрх байдлыг өөрчлөхгүй байх	-	-	Үйл ажиллагааны туршид	
УРГАМЛАН НӨМРӨГ					
Машин техникээс тос Тосолгооны материал асгарч ургамлан нөмрөгийг бохирдуулах	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	-	-	Үйл ажиллагааны туршид	
Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар тээвэрлэх ба хүнд даацын машин механизмын нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах, ургах чадвараа алдах	Уурхайн авто замуудыг дулаан улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	-	Үйл ажиллагааны туршид	

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ургамлан нөмрөг бохирдох	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, тохиолдлыг бүртгэх, бохирдсон хөрсийн тоо хэмжээг гаргах	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	-	Үйл ажиллагааны туршид	
Ургамалан нөмрөгт нөлөөлөх тоосжилтийг багасгах	Уурхайн доторх замуудыг тогтоож тусгайлан засварлах	0.2	0.2	Үйл ажиллагааны туршид	
Уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх, тэсэлгээ хийх, гадаад тээврийн авто машинууд, хуурай баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас шалтгаалан	Тухайн бүс нутагт ургаж буй өвс ургамалыг төрөлжүүлэн судлаж тарьж ургуулах ажлыг зохион байгуулж байгалийн онгон тогтоцыг хэвээр хадгалах	0.3	0.3	2025 онд	
Ил уурхайн ашиглалт овоолгийн ажил зэрэг хүн мал амьтаны хөлийн мөрөөр гишгэгдэж үгүй болох зэрэг		-	-	Үйл ажиллагааны туршид	
Гал түймэрээс сэргийлэх арга хэмжээ	Гал түймрийн аюул ослоос урьдчилан сэргийлэх тэмцэх, тусгайлан хүн дадлагажуулж сургах	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан			
АМЬТНЫ АЙМАГ					
Хөрсөнд үүрлэдэг жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	-	-	Үйл ажиллагааны туршид	
Тоосжилтын улмаас уурхайн ойр орчмын амьдрах орчин доройтох	Уурхайн тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	-	Үйл ажиллагааны туршид	

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Шатахуун, тослох материал асгарснаас амьдрах орчин бохирдох, доройтох	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	-	Үйл ажиллагааны туршид	
Хог хаягдлыг (хоолны) эмх замбраагүй хаяснаас болж зарим махчин амьтад идэх, амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан	-	Үйл ажиллагааны туршид	
	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж биобэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд хальгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх				
Мониторингийн бүртгэл хийснээр уурхайн орчны хөхтөн амьтад болон шувуудын өсөлт хорогдолын тоог тогтоох	Ажиглалт мониторингийн бүртгэл хийх	Үйл ажиллагааны зардалд тусгах	0.4	Үйл ажиллагааны туршид	
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал		2,400,000			

3.4.2. Нөхөн сэргээлт

Үүдийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн нөхөн сэргээлтийн ажил нь уурхайн ашиглалтын 6 дахь жилээс хийгдэж эхлэх тул тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн зардлыг тусгаагүй болно.

3.4.3. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Үүдийн төмрийн хүдрийн орд ашиглах төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

3.4.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Дорнын хүдэр” ХХК нь уурхайн БОМТ-ний хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай бөгөөд түүний хэрэгжилтийн тайланг жил бүрийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланд тусгаж байх үүрэгтэй. Төслийн нөхөн сэргээлтийн ажлын дараагаар үлдэх нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

Үүдийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалд нийт 6,000,000 төгрөг зарцуулах тооцоолол гарсан ба уг арга хэмжээг Байгаль орчин аялал жуулчлалын газартай зөвшилцөж сумын нутаг дэвсгэрт байгаа эзэн нь тодорхойгүй ухагдаж орхигдсон газрыг булах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

Энэхүү БОННУ тайланд тусгасан дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь зөвхөн санал болгож буй арга хэмжээнүүд бөгөөд дүйцүүлэн хамгааллыг Байгаль орчин аялал жуулчлалын газартай болон сум орон нутгийн удирдлага, албан хаагчидтай хамтран хэлэлцэж, зөвшилцсөний үндсэн дээр гүйцэтгэх шаардлагатай.

Хүснэгт-№3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Хяналт тавих газар	Байршил	Зардал
1	Булган сумын БО газар	47.97056 113,952062	3 000 000
2	Матад сумын БО газар	46 ⁰ 57' 35,39” 115 ⁰ 18' 13.30”	3 000 000
Нийт			6 000 000

Булган сумын нөхөн сэргээлт хийлгэх талбайн тойм зураг



Шаардлагатай тохиолдолд Матад, Булган сумдын орон нутаг засаг захиргаатай тохиролцон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг явуулна.

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Хүснэгт-№3.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилго	Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлж болохуйц газар	Үндэслэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал	Хамтрах талууд	Хэрэгжүүлэх хугацаа
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.	Байгаль орчин аялал жуулчлалын газартай зөвлөлдөх	Усны эх үүсвэрийн хомсдлоос бэлчээрийн менежментэнд нөлөөлөх	Бэлчээрийн шийдэлтэй худаг гаргах	1,500,000	БОАЖГ	
		Тус БЦГ-т малын тоо толгой нэмэгдсэнээс үүдэн бэлчээрийн талхагдал нэмэгдэж, зарим булгийн дарагдах зэрэг сөрөг нөлөөлөл үүсч байна.	Хамгаалах шаардлагатай булгийн эхийг хаших	1,500,000	БОАЖГ	
		Бүс нутгийн бэлчээрийн менежментийг сайжруулах ажлыг үе шаттайгаар малчид, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлснээр зэрлэг амьтадын амьдрах орчин болсон бэлчээрийн чанар, хүртээмж нэмэгдэхийн зэрэгцээ малчдын амьжиргаа дээшилнэ.	Бэлчээрийн менежментийг сайжруулах	1,000,000	БОАЖ, ЗДТГ болон нутгийн малчид	
		Идээшил нутгийн давхцал, хууль бус ангийн нөлөөгөөр цагаан зээрийн тоо толгой цөөрөх	Амьтны тухай хууль тогтоомжийг иргэдэд таниулах ажлыг зохион байгуулах	500,000	БОАЖ	
			Нутгийн малчдын иргэдийг байгаль хамгаалах арга хэмжээнд оролцуулж, хамтран ажиллах, урамшуулах	500,000	БОАЖ	
		Аймгийн БОГазрын болон Матад, Булган сумын ЗДТГ-тай хамтран тухайн сумдын нутаг дэвсгэрт хүний буруутай үйл ажиллагаанаас үүссэн нүхийг бөглөх	Хөрсний доройтол үүсэхээс сэргийлэх	1,000,000	БОАЖ	

3.4.5 . Соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

Өмнө нь хийгдэж байсан ажил тул 2025 онд палентологийн судалгааны ажлыг хийлгэхгүй гэсэн үг юмаа.

3.4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

2025 онд нийт ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулна. Гэнэтийн осол аваар гамшигийн үед ажиллах комиссыг зхирдлын тушаалаар батлан сургалт суртчилгаа үзүүлэн тэмдэг тэмдэглэгээ зэргийг хийж осол аваараас урьдчлан сэргийлж ажиллана. Мөн уурхайн дотоод косиссын багыг 7 хоногт 1 удаа шалгалт хийлгэнэ. Ажилчдын дунд аваарыг мэдээллэх хуудсыг ажиллуулна.

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Хүснэгт-№3.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Нөлөөллөөс зайлс хийх үйл ажиллагаа	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Баяжуулах үйлдвэр уурхайн тосгон хооронд явган хүний зам тавих хашлага хийх	Төслийн талбайд	300.0	2025 онд
Аянга зайлуулагчийг нэмж тавих	Баяжуулах үйлдвэрт, уурхайн тосгон	100.0	2025 онд
Барилга байгууламжийн зураг төсөлд цаг агаарын нөхцлүүдийг тусгах	Баяжуулах үйлдвэрт, уурхайн тосгон		2025 онд
Уурхайд онцгой байдлын журам мөрдүүлэх	Төслийн нийт ачилчид		Төслийн хугацаанд байнга
Үерийн болон гал түймэр, мал амьтан орхоос сэргийлсэн шуудууг дагуулан торон хашаа татах	Төслийн талбайд	100.0	2025-2026 онуудад
Гадаад тээврийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээ нэмэх	ХЭБЭА	200.0	2025 онд
Уурхайн технологийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээг сайжруулж нэмэх	Төслийн талбайд	100.0	2025 онд
Гадаргын усыг соруулан үерийн даланруу урсгах хүн мал унахаас хамгаалж хамгаалалтын зурвас татах		100.0	
Орчны тоосжилтийг багасгаж харагдах орчныг сайжруулан баяжуулах үйлдвэрт хаалт хамгаалалт урсгуур хийх	Баяжуулах үйлдвэрт	200.0	2025 онд
Гал түймрийн аюул ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүн сургах, тоног төхөөрөмжийн хангалт зэргийг шийдвэрлэх	Уурхайн хэмжээнд	200.0	2025 онд
Нийт		1300.0	

3.4.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Дорнын хүдэр ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Уурхайн хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад жилд дунджаар 1.5 сая төгрөг төсөвлөх бөгөөд доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ахуйн хог хаягдлыг (цаас, баглаа боодлын хайрцаг, хуванцар сав, металл, төмөр, шил, нийлэг материал г.м) ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулна.

Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаана. Ашигласан тосыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна.

Уурхайн хотхонд түр хог хаягдлын цэгийг орон нутгийн зөвшөөрөлтэйгөөр байгуулсан ба түр хогийн цэгт хог хаягдлыг хаяхдаа ялган ангилах ба дараах 2 өнгөөр ялгасан хогийн савнуудыг энгийн болон хуванцар сав хаях зориулалтаар байрлуулна.

Хаягдал зайлуулах нүх/савыг сард нэгээс доошгүй удаа ариутгах ба бие засах газар, шүршүүрийг өдөр бүр цэвэрлэж, ариутгана. Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар бохир усны нүх, сав, бие засах газрыг ариутган булж тэгшлэн нөхөн сэргээнэ. Бага агуулгатай эфелийн овоолгын бүртгэл мэдээллийг хөтөлж уурхайн хаалт нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд MNS 5917:2008 стандартад заасны дагуу 20 градусаас ихгүй налуутайгаар хэлбэршүүлж орон нутгийн удирдлагад холбогдох газрын зураг, мэдээллийн хамт хүлээлгэн өгнө.

Ажилчдын хариуцлагагүй байдал, машин техникийн эвдрэл гэмтэл зэргээс хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан авч, тусгаарлагч гадаргуу дээр овоолон, 18-22%-ийн хлорт уусмалаар бороожуулж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээг 0.05 мг/кг-аас ихгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд буцаан байршуулна.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаар зохицуулагдаж байна.

Энэхүү төслийн хүрээнд төмрийн хүдэр олборлох явцад төсөл хэрэгжүүлэгч дараах эрх эзэлж үүрэг хүлээнэ.

- Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах
- Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх.
- Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах.
- Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулсан биелэлтийг хангаж ажиллах.
- Аюултай хог хаягдлыг бусад төрлийн хог хаягдалтай хамт тээвэрлэхгүй байх.
- Хог хаягдлыг зориулалтын саванд хийж, зориулалтын газар тушаах.

Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ШТМ асгарсан тохиолдол тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд мэдээлэх, уурхайн дотоод журамд хог хаягдлыг ангилах талаар тусган ажиллана. Төсөл хэрэгжих хугацаанд үүссэн хатуу хог хаягдлыг дээрх зөвлөмжийн дагуу зайлуулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.

Уурхайн кемп болон баяжуулах үйлдвэрийн орчинд байгаа төмрийн хог хаягдлыг ангилан ялгаж Дорнод аймгийн Матад суман дахь Матад БЭШН ХХК-тай гэрээ хийн хогийн цэгт хүргэнэ.

Уурхайн хог баяжуулах үйлдвэр, Ил уурхайд ажиллаж буй техикүүдээс гарсан тос масло, аккумулятор зэрэг аюултай хог хаягдлыг Матад БЭШН ХХК-тай гэрээ хийн хогийн цэгт хүргэнэ.

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Хүснэгт-№3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөлөл	Сөрөг нөлөөлөлийг арилгах	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
ХӨРСӨН бүрхэвч								
Уурхайн техикүүдээс гарсан тос масло	Тусгай хашаалж битүүмжилж хаягжуулсан талбайд хадгалах, асгарсан тохиолдолд саармагжуулах	Аюултай хог хаягдлын цэг		Одоо байгаа ба 2025 оны хуримтлагдах хэмжээ	500.0	Байгаль орчны мэргэжилтэн	Нийт аюултай бодсийн тоо хэмжээ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай. Шинэчилсэн найруулга Дорнын хүдэр ХХК-ны дотоод журам, Хог хяагдлын тухай хууль, Байгаль орчны менежментийн тухай хууль Холбогдох стандарт журмууд
Акумулятор нь ил задгай хаяхад хөрс бохирдох	Ажиллагаанаас гарсан тухай бүр тусгай бэлдсэн талбайд хадгалан зөөвөрлөнө	Аюултай хог хаягдлын цэг		2025 оны хуримтлагдах хэмжээ	250.0	Байгаль орчны мэргэжилтэн	Тоо ширхэг бүртгэлжилт	
Уурхайн хэмжээнд ашиглагдаж байгаа батерей нь хөрсний тэнцвэрт байдлыг алдагдуулна	Тусгай бэлдсэн талайд хадгалан тушаана	Аюултай хог хаягдлын цэг		2025 оны хуримтлагдах хэмжээ	100.0	Байгаль орчны мэргэжилтэн	Тоо ширхэг бүртгэлжилт	
Уурхайн кемпээс гарч буй хатуу хог хаягдал нь хөрсийг бохирдуулж хөрсийг доройтуулан салхинд хийсч хөрсний тэнцвэрт байдлыг алдагдуулна	Хашаажуулан ангилан ялгаж түр хадгалах цэгт хадгалан гэрээлэгч компанаар зөөвөрлүүлнэ	Энгийн хог хаягдлын цэгт		2025 оны хуримтлагдах хэмжээ	300.0	Байгаль орчны мэргэжилтэн, ИТА		
Кемпээс гарч буй шингэн хог хаягдал нь хөрсөнд нэвчин хөрсийг доройтуулна	Жилд 1 удаа Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-аар бохирыг соруулна.	Ажилчдын амрах байр, гал тогоо		2025 оны хуримтлагдах хэмжээ	100.0	Байгаль орчны мэргэжилтэн, кемп менежер	Соруулалтаар	
Хоолны үлдэгдэл нь үер салхи, дугуй зэргээс дамжин тархаж хүн амьтан ургамалд сөргөөр нөлөөлнө	Тусгайлан нүх ухаж хийж байх	Гал тогоо		2025 оны хуримтлагдах хэмжээ	100.0	Байгаль орчны мэргэжилтэн, кемп менежер		
АГААРын чанар								
Хоолны үлдэгдэл өмхийрч агаарт цацагдан орчин тойрныг өмхийрүүлдэг	Халдваргүйжүүлэн булах	Гал тогоо		2025 оны хуримтлагдах хэмжээ	50.0	Байгаль орчны мэргэжилтэн, кемп менежер		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай. Шинэчилсэн найруулга Дорнын хүдэр ХХК-ны дотоод журам, Хог хяагдлын тухай хууль,
ШТМ нь агаарт ууршин агаарыг бохирдуулдаг	Битүү саванд хийн асгарсан хэсгийг саармагжуулах	Уурхайн хэмжээнд		2025 онд	250.0	Байгаль орчны мэргэжилтэн,	Тоо бүртгэлээр	
Уурын зуухнаас гарч утаа нь агаар мандалыг бохирдуулна	Агаарыг цэвэрлэх мод бутыг тарина	Кемпийн урд мод тарьж төгөл болгох		2025-2026 он	300.0	Байгаль орчны мэргэжилтэн, кемп менежер	Тоо бүртгэлээр	

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Уурын зуухнаас гарч буй үнс агаар болон хөрсийг ихээр бохирдуулдаг	Үнсийг тусгай ухсан нүхэнд хийн хадгалж гэрээт байгууллагаар зөөвөрлүүлнэ	Уурхайн кемп		Ашиглалтын жилүүдэд				Байгаль орчны менежментийн тухай хууль Холбогдох стандарт журмууд
Усан орчин								
Ил задгай хог хаяснаас хийсч худаг бохирдуулах	Эрүүл ахуйн бүс тогтоож хашаалах							
ШТС үер усны нөлөөлөлөөс шалтгаалан урсаж ус бохирдуулах	Байшинг засж янзлах				50.0			
Нийт					2000.0			

3.4.8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Үүдийн төмрийн хүдрийн орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрт авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар Газрын чанарын улсын хянан баталгааг хийлгэх, цаашид 5 жил тутамд хийлгэх шаардлагатай. Мөн Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай юм. 2025 онд манай компани орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дээж авах тандах судлах ажлыг Дорнод аймгийн Ус цаг уур шинжилгээний газартай хийсэн гэрээний дагуу хийж гүйцэтгэнэ.

Ургамалын нөмрөг, хөрс, ус зэрэг байгаль орчинтой холбоотой ажлыг “Грийн солюшн партнерс ХХК”-ны мэргэжилтэнгүүд хийж гүйцэтгэнэ. Сумдын байгаль орчны байцаагч болон компанийн байгаль орчны мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Хүснэгт-№3.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, сая.төг
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Төслийн нийт хугацаанд	500.0
3.	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдаад байгаа
4.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Төслийн нийт хугацаанд	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдаад байгаа
5.	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Төслийн нийт хугацаанд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
6.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Дорнод аймгийн БОАЖГ-т хүргэн өгч байх	2025 оны 11 сарын дотор	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
7.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд	
8.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитийг хийлгэнэ	2025 онд	1000.0
Нийт зардал			1500.0 төг

3.5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Үүдийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч Дорнын хүдэр ХХК-д өгөгдсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад Дорнын хүдэр ХХК-иас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч ОХШХ-г хэрэгжүүлэхдээ хяналт шинжилгээний дээж, сорьцыг Дорнод аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний лабораторд батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэх ба хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, орон нутгийн байгаль орчны байцаагч, орон

нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын дор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

Манай компани нь 2025 онд уурхайн ойролцоо байрладаг худаганд 4дээж, гадаад тээвэртийн зам дагуу 7 дээж, уурхайн орчмын хөрс ургамалаас тус бүр 2 дээж авахаар төлөвлөж шинж чанар нь өөрчлөгдсөн тохиолдолд шаардлагатай сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээг авч ажиллана. Ус цаг уур шинжилгээний газраас шинжилгээ хийлгэсэн тухай бүр дүгнүүлэн дүгнэлт авч ажиллана.

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

Хүснэгт-№3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Нийт зардал, төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар					
- Тоосжилт (PM10, PSM, PM25). - Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ. - Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин). - Бохирдлын цэгэн эх үүсвэр (O2, SO2, NO2, CO).	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил (уурхайн карьер, дотоод тээврийн зам, гадаад овоолго, уурхайн тосгон г.м), нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт цэгүүдэд	Дотоодын хяналт шинжилгээг сард 1 удаа	Эх үүсвэрүүдийн байршил, нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн газруудад арга зүйн дагуу	Дотоод ү/а	MNS3113:1981.Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага. MNS0017-2-3-16:1988 Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ. MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга. MNS5061:2001.Нүүрс хүчлийн хий-CO2 тодорхойлох эзлэхүүний арга. MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга. MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга. MNS0017.2.5.12:8988. Хүхэрлэгхий-SO2 шинжлэх ТХМ буюу аэрозалины арга. MNS0017.2.5.11-1998. азотын давхар исэл.
			Эх үүсвэрүүдийн байршил, нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчмын газруудадарга зүйн дагуу	300.0	
Усан орчин					
Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металын шинжилгээ, БХХ болон цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан үзүүлэлтүүд	Уурхайн ашиглалтын худгууд	Дотоодын хяналт шинжилгээний хүрээнд улиралд 1 удаа (шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийг өөрчилж болно)	Усны дээж авах сав, хээрийн хэмжилтийн багаж (pH/EC/TDS meter, TDS-3) зэргийг ашиглан дээж авах ба дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэх	Дотоод ү/а	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ. MNS3935:1986 Унд ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага. MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх;

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

		Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 1 удаа			MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох; MNS3934:1986иУндны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах
Хөрсөн бүрхэвч					
Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO3), хөдөлгөөнт кали (K2O), хөдөлгөөнт фосфор (P2O5), Шингээгдсэн сууриуд Ca, Mg	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд хоёр удаа	Итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээ	300.0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам. MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин					
Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)	Засварын газар, хогийн цэг орчимд				
Амьтны аймаг					
Туруутан амьтдын байршил нутаг, тоо толгой,шилжилт хөдөлгөөн; мөлхөгчид, мэрэгчдийн нягтшил зэргийг тогтоох	Төслийн талбай, түүний ойр орчмын нутагт	Жилд 1 удаа	Биологийн хүрээлэнгийн баталсан судалгааны арга зүйн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх	200.0	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
Жил бүр шувуудын нүүдлийн үеэр ажиглалт, мониторинг хийх	Төслийн талбай болон түүний орчмын уст цэг, бусад бүх амьдрах орчинд	Жилд 1 удаа намар (8.20-9.20)			Батлагдсан арга зүйн дагуу
Ургамлын аймаг					
Хяналтын талбай бүрт 30 метрийн урттай трансектийг давтамжтай тавьж, трансект тус бүрт он,сар, өдөр, шалгасан хүний нэр, трансектийн бүртгэлийн дугаар, газрын хэвшил, ургамлын төрөл зүйл зэрэг мэдээллүүдийг авна. Мөн ургамлан нөмрөгийн дээд, доод бүрхэц, ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, бүлгэмдэлд эзлэх хувь зэргийг гаргана.Үүнд: дундаж өндөр см, биомасс, кг/га. Хяналтын талбай бүрийн (25х25м,1х1м,10х10м) ургамлын зүйлийн бүрдэл, бүрхэц, бүлгэмдэлд эзлэх %. Хяналтын явцад төслийн талбайд жилийн дундаж хур тунадасыг хэмжиж, тухайн жилийн ургамлын био масстай хур тунадасны хэмжээг харьцуулах	Төслийн байгууламжийн талбай дахь судалгааны цэг, Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэгүүдэд	Төсөл хэрэгжилтийн явцад болон нөхөн сэргээлтийн шатанд жилд 1 удаа (6-7сард)	Батлагдсан арга зүйн дагуу	200.0	Батлагдсан арга зүйн дагуу
Орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал				1000.0	

**3.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь
шалгах ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний
төлөвлөгөө**

Дорнын хүдэр ХХК-ны 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөны биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гаргасан а/618 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу гарган Дорнод аймгийн БОАЖГазарт хүргүүлнэ.

Дорнод аймгийн БОАЖГазрын ажлын хэсэг хянаж үзээд дараах ажлуудыг 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх санал өгсөн тул манай компани дараах байдлаар төлөвлөж байна.

Хүснэгт-№3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх санал

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Авто засварын цэгийг хатуу хучилттай болгох	500.0	2025 онд	Үүдийн уурхай	2025 оны III-р улиралд багтаана
2	Уурхайн тээврийн замын асуудлыг бүрэн шийдвэрлэх	Тодорхойгүй	2025 онд	Дорнын хүдэр ХХК	Зөвшөөрөгдөж буй
3	Уурхайн дотор болон бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа замын маршрутыг тодорхой болгож тэмдэгжүүлэх	500.0	2025 онд	Үүдийн уурхай	Мэргэжилийн компаниар хэмжилт хийлгүүлэн тэмдэгжүүлнэ
4	Хөрс ус агаарт шинжилгээ хийх мэргэжилийн компанийг сонгох	Тодорхойгүй	2025-2026	Үүдийн уурхай	Дорнод аймгийн Цаг уур орчны шинжилгээний газартай шинэчилсэн гэрээ хийнэ
5	ОХШХ орон нутгийн төрийн байгууллагаас хяналтаар хүн оролцуулах	Тодорхойгүй	2025 онд	Үүдийн уурхай	Матад, Булган сумын байгаль орчны улсын байцаагчыг байлцуулна
Нийт		1000.0			

**“ДОРНЫН ХҮДЭР” ХХК-Н “ҮҮДИЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 ОН)**

**3.7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт-№3.9. Бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Д/д	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Хамтран зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1	Дорнод аймагт зохион байгуулагддаг “Нээлттэй өдөрлөг”-г оролцож, 2025 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга хийнэ.	Нээлттэй өдөрлөг зохион байгуулах	Байгаль орчны хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх	2025 оны 11-р сар	300,000	“Дорнын хүдэр” ХХК-ийн байгууль орчны мэргэжилтэн, ИТА	Дорнод аймаг
2	Дорнод аймгийн Матад, Булган сумуудад “Нээлттэй өдөрлөг”-г зохион байгуулж 2025 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга хийнэ.	Нээлттэй өдөрлөг зохион байгуулах	Байгаль орчны хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх	2025 оны 11-р сар	400,000	“Дорнын хүдэр” ХХК –ийн байгууль орчны мэргэжилтэн, ИТА	Дорнод аймаг Матад, Булган сум
3	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгах	Компанийн албан ёсны вэб хуудас	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	2025 оны III улирал	Зардалгүй	Байгаль орчны мэргэжилтэн, ИТА	
4	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт	Шалгалтын дүгнэлт	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	2025 оны 11 сар	200,0		Үүдийн уурхай
5	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг 2024.10 сард багтаан орон нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах	Танилцуулга хийх	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 онд хэрэгжүүлсэн эсэх үр дүн	2025 оны 2-р улирал			Дорнод аймгийн Матад Булган сум
6	Байгаль орчны менежментийн тайланг орон нутгийн иргэдийн төлөөлөлд танилцуулах	Үйл ажиллагааны тайлан	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, үр дүн	2025 оны 11-р сард	100.0		Дорнод аймгийн Матад Булган сум